

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

 Х.НЯМБААТАР

2025 оны ... дугаар сарын ...

“УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ”-Н 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

“УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ”-Н
Захирал



П.Даваасүрэн



Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	3
ГУРАВ. АЛСЫН ХАРАА	9
ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО	10
ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	10
ЗУРГАА. БҮТЭЦ ОРОН ТОО	13
ДОЛОО. СТРАТЕГИ ЗОРИЛГО	14
НАЙМ. МУЗЕЙН ТАНИЛЦУУЛГА, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	14
ЕС. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
АРАВ. ХАВСРАЛТ	20

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Нийслэлийг 2024-2028 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрэх түвшнийг баримтлан Музейн тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, холбогдох эрх зүйн баримт бичгийн чиг үүргийн хүрээнд 4 зорилго 8 зорилт, 31 арга хэмжээг 2024-2028 онд хэрэгжүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнана.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам" болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 100 дугаар тушаалаар шинэчлэгдсэн "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал"-д нийцүүлэн стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэх шаардлага үүсэж байгаа юм. "Нийслэлийг 2024-2028 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Улаанбаатар хотын музейн 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг шинээр боловсруулж байна.

Төрийн албаны тухай хуулийн (2017 оны шинэчилсэн найруулга) 53 дугаар зүйлийн 53.1-д зааснаар "Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна" гэж заасны дагуу Улаанбаатар хотын музейн өнөөгийн нөхцөл байдал, давуу болон сул талууд, тулгамдаж буй асуудлууд, мөн ирээдүйн боломжуудыг нэг бүрчлэн судалж, дотоод болон гадаад орчны шинжилгээг хийсэн. Үүний үр дүнд, цуглуулга хадгалалт, үзэсгэлэн үйлчилгээ, боловсролын хөтөлбөр, санхүүгийн тогтвортой байдал, хүний нөөцийн бодлого зэрэг хэд хэдэн үндсэн чиглэлд анхаарлаа хандуулж, тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандатын шинжилгээг хийхдээ Монгол Улсын Үндсэн хууль болон Соёл, музейн салбарт шууд хамаарах 7 хууль, төрийн алба, төсөв санхүү зэрэгт хамаарах 20 буюу нийт 27 хуулийн хүрээнд тодорхойлж Улаанбаатар хотын музейн 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг 4 зорилго 8 зорилт, 31 арга хэмжээг дүрмээр хүлээсэн болон хуулиар олгосон гэсэн 2 чиг үүрэгт ангилан хэрэгжүүлэхээр боловсруулав.

Хүснэгт 1. Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулиуд

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		27
	Тухайн салбарын хуулиуд Тоо: 7	1. Монгол Улсын Үндсэн хууль 2. Соёлын тухай 3. Соёлын өвийг хамгаалах тухай 4. Музейн тухай 5. Зөвшөөрлийн тухай 6. Боловсролын тухай 7. Оюуны өмчийн тухай

Үүнээс:	Нийтлэг мөрддөг хуулиуд Тоо: 20	1. Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай 2. Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай 3. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай 4. Төрийн албаны тухай 5. Төсвийн тухай 6. Нягтлан бодох бүртгэлийн тухай 7. Шилэн дансны тухай 8. Төрийн хэмнэлтийн тухай 9. Архив, албан бичиг хөтлөлтийн тухай 10. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 11. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай 12. Төрийн хяналт шалгалтын тухай 13. Хөдөлмөрийн тухай 14. Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай 15. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай 16. Ахмад настны тухай 17. Гамшгаас хамгаалах тухай 18. Галын аюулгүй байдлын тухай 19. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай 20. Авлигын эсрэг
---------	------------------------------------	--

Хүснэгт 2. Улаанбаатар хотын музейн стратеги төлөвлөгөөний чиг үүргийн ангилал

Стратегийн зорилго	Стратегийн зорилт	Холбогдох хууль	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Дүрмээр хүлээсэн чиг үүрэг: Музейн зорилго, үйл ажиллагааны чиглэл-Хотын түүх, соёлын өвийг хадгалах, хамгаалах, судлан шинжлэх, сурталчлан таниулах, соён гэгээрүүлэхэд дэмжлэг үзүүлэх			
Стратеги зорилго 1: Улаанбаатар хотын соёлын биет өвийг цуглуулах, бүртгэх, хадгалж хамгаалах үйл ажиллагааг тогтвортой хөгжүүлж, олон нийтэд хүртээмжтэй, судалгаанд түшиглэсэн музейн сан хөмрөгийг бүрдүүлнэ.	Зорилт 1. Улаанбаатар хотын түүхэнд холбогдох соёлын биет өвөөр сан хөмрөгийг баяжуулна.	- Соёлын тухай - Соёлын өвийг хамгаалах тухай - Музейн тухай - Нягтлан бодох бүртгэлийн тухай	НЗДТГ СӨТ Олон нийтийн байгууллага Иргэд
	Зорилт 2. Бүртгэл мэдээллийн сангийн үйл ажиллагааг хөгжүүлнэ.	- Соёлын өвийг хамгаалах тухай - Музейн тухай - Зөвшөөрлийн тухай - Оюуны өмчийн тухай	ССАЖЗЯ СӨТ НСУГ
	Зорилт 3. Музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтын баталгаат орчныг бүрдүүлнэ.	- Соёлын тухай - Музейн тухай - Нягтлан бодох бүртгэлийн тухай	СӨТ Музей, Галларей
Стратеги зорилго 2: Улаанбаатар хотын түүхийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж, хүртээмжтэй	Зорилт 4. Улаанбаатар хотын түүх судлалыг хөгжүүлнэ.	- Соёлын тухай - Музейн тухай	НЗДТГ ССАЖЗЯ СӨТ НСУГ Музей, Галларей

хэлбэрээр түгээн дэлгэрүүлж, хотын соёлтой иргэнийг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажиллагааг хэрэгжүүлнэ. үйл			Түүх, Археологийн Хүрээлэн
2.Хуулиар олгосон чиг үүрэг: Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй болгох			
Стратеги зорилго 3: Эрсдэлийн менежментийг сайжруулж, төсвийн хэмнэлтийг хэрэгжүүлнэ. төсвийн	Зорилт 6. Төсвийн төлөвлөлт, зарцуулалт болон тайлагналт, ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулна.	-Төсвийн тухай -Нягтлан бодох бүртгэлийн тухай -Шилэн дансны тухай -Төрийн хэмнэлтийн тухай - Авлигын эсрэг -Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай	НЗДТГ ССАЖЗЯ
	Зорилт 7. Музейн үзмэр, барилга байгууламж, ажилтнууд болон үзэгчдийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй гамшиг, мэдээлэл технологийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулна.	-Гамшгаас хамгаалах тухай -Галын аюулгүй байдлын тухай	НЗДТГ НОБГ НЦЕГ
Стратеги зорилго 4: Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.	Зорилт 8.1 Зорилго, алсын хараа, стратегийг сайжруулна.	-Монгол улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай -Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай -Төрийн хяналт шалгалтын тухай - Архив, албан бичиг хөтлөлтийн тухай -Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай	НЗДТГ ССАЖЗЯ НҮТББ ААН Иргэд
	Зорилт 8.2 Байгууллагын соёл ба манлайллыг хөгжүүлнэ.		
	Зорилт 8.3 Оролцогч талуудын оролцоог хангана.		
	Зорилт 8.4 Тогтвортой үнэ цэнийг бий болгоно.		
	Зорилт 8.5 Гүйцэтгэл ба өөрчлөлтийг удирдлагыг сайжруулна.		

	Зорилт 8.6 Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголтыг дээшлүүлнэ.	-Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай -Ахмад настны тухай	
	Зорилт 8.7 Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэл		

Холбогдогч талуудыг тодорхойлох;

Холбогдогч талуудыг тодорхойлохдоо Улаанбаатар хотын музейгээс бусад байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэн тодорхойлов. Улаанбаатар хотын музей нь доорх хэлбэрээр үйл ажиллагаагаа зохион байгуулдаг байна. Үүнд:

1. Дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, үр дүнг тооцох, мэдээллээр хангах, ажлынхаа үр дүнг тайлагнах, үйл ажиллагаагаа уялдуулах, захиргаа аж ахуй, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг авах
2. Нийслэлийн харьяа байгууллага, чиг үүрэг нэг соёлын байгууллагууд, НҮТББ, ААН, иргэдтэй бодлогын удирдамжаар хамтран ажиллах, мэдээллээр хангах, санал хүсэлтийг хүлээн авах, эргэх холбоогоор хангах, үйлчилгээ үзүүлэх, хөтөлбөр төслийг хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ хийх, үр дүнг тооцох
3. Дотогшоо буюу байгууллагыг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, стратегийн төлөвлөлт хийх, төсөл хөтөлбөр зохиох, архив бичиг хэргийг хөтлөх, мэргэжилтэн хоорондын ажил үүргийг уялдуулан зохицуулах, хяналт тавих, үр дүнг тооцох

Улаанбаатар хотын музейн үйл ажиллагаанд холбогдогч талуудыг дараах зурагт харуулав.

Зураг 1. Улаанбаатар хотын музейн үйл ажиллагаанд холбогдогч талууд

